

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨМА-2022/40/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.02.23 № 139

танай _____-ны № _____-т

Г МАНДАЛ-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА О.ОТГОНБАЯР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-овоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мандал-овоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бичиг хэргийн болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 563.545 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1,629.740 төгрөгийн шатахуун авсан зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, ангилал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

010022063

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to read 'С.Цэрэнбаяр', is written over a faint red rectangular stamp.

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	0.7	25.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16.2	36.9
	Нийт хөрөнгийн дүн	16.8	62.5
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	16.8	62.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	16.8	62.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	68.7	75.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	81.4	78.1
	Үйл ажиллагааны үр дүн	(12.7)	(3.1)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.3	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(12.9)	(3.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14.7	16.8
	Тайлант оны үр дүн	45.7	45.7
	Эцсийн үлдэгдэл	60.4	62.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	67.2	75.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	67.2	75.0
	Үйл ажиллагааны ЦМГ	0.0	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	71.6	69.7
	Урсгал зардал	71.6	69.7
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	71.6	71.6
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71.6	71.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал-овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавхыг дээшлүүлэн, иргэдийн төлөөллөөрөө дамжуулан нутаг дэвсгэрийнхээ иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалан ажиллана" гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал,
- “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол,

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1.7 сая төгрөгийн шатахуун авсан байна,
- Хурлын нөөц сангаас 0.8 сая төгрөг, бараа үйлчилгээний зардлаас 0.3 сая төгрөгийг уралдаан тэмцээн зохион байгуулах зардалд зарцуулсан,
- бичиг хэргийн болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан

Дөрөв. Аудитын гол асуудал

Мандал-овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал-овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь

- аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй,
- 49 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 9.3 сая төгрөгийн алдааг залруулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам", Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 албан шаардлага өгсөн.

4.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Тайлант онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 1.6 сая төгрөгийн шатахуун авсан

Өгсөн албан шаардлага:

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах

2.Илрүүлэлт:

бичиг хэргийн болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Өгсөн албан шаардлага:

Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

3.Илрүүлэлт:

149 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй байна.

Өгсөн албан шаардлага:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.5." төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор" мэдээлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

4.Илрүүлэлт:

149 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулаагүй байна. нөөц сангаас 0.8 сая төгрөг ,бараа үйлчилгээний зардлаас 0.3 сая төгрөгийг уралдаан тэмцээн зохион байгуулах зардалд зарцуулсан байна.

Өгсөн албан шаардлага:

Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авч байгаа арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах

Аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 5 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИИТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	6	12,6	3	9,3	0	0	1	3,3	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	6	12,6	3	9,3	0	0	1	3,3	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	0	0	0	0	0	1	0	0	0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	1	0	0	0	0	0	1	0	0	0
	НИИТ ДҮН	7	12,6	3	9,3	0	0	2	3,3	0	0

